



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2000 оны 5- дугаар
сарын 24- ны өдөр

Дугаар 145

Улаанбаатар хот

Дүрэм, орон тоо, зохион
байгуулалтын тухай

Монгол улсын Засгийн газрын 2000 оны 71 дүгээр тогтоолыг үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Нийслэлийн Захирагчийн ажлын албаны харъяанд Хөрөнгө оруулалт, хот тохижилтын газрыг байгуулсантай холбогдуулан тус газрын дүрмийг 1 дүгээр хавсралтаар, бүтэц орон тооны нэгжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хот тохижилтын ажлын санхүүжилтийг Хөрөнгө оруулалт, хот тохижилтын газраар гүйцэтгүүлэн барилгын төсөв зохиох, заавар батлах тухай Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1998 оны 200 тоот тушаалын дагуу хяналт тавиулж, санхүүжүүлж байхыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн хэлтэс /Д.Гонгор/-т зөвшөөрсүгэй.

3. Зохион байгуулалтын өөрчлөлт орсонтой холбогдуулан Хот тохижилтын хэлтсийн мэргэжилтнүүдийн хэрэглэж байсан ширээ, сандал, бусад тоног төхөөрөмжийг Захирагчийн ажлын албанаас Хөрөнгө оруулалт, хот тохижилтын газарт балансаас балансад шилжүүлэхийг Хотын ерөнхий менежер /Э.Гомбожав/-т зөвшөөрсүгэй.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2000 оны 5 дугаар сарын 24 өдрийн 145 дугаар захирамжийн 1-р хавсралт

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Нийслэлийн хөрөнгө оруулалт, хот тохижилтын газар нь /цаашид газар гэнэ/ улс, хотын төсөв, орон сууц, замын сан, гадаадын зээл тусламж, бусад төрлийн эх үүсвэрийн хөрөнгө оруулалт бүхий Нийслэл хотын захиалгатай орон сууц, инженерийн байгууламжууд, зам, гүүр, далан суваг, гэрэлтүүлэг, реклам чимэглэл, ногоон байгууламж, хөшөө дурсгал болон архитектурын хийц, соёл боловсрол, эрүүл мэнд, ахуйн болон нийтийн үйлчилгээний зориулалттай барилга объектыг шинээр барих, угсрах, шинэчлэн өргөтгөх, засварлаж тохижуулах ажилд батлагдсан хөрөнгийг төвлөрүүлж зориулалтынх нь дагуу зарцуулах, түүний үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг захиалагчийн болон техник хяналтын бодлогыг хэрэгжүүлэх үүрэг бүхий мэргэжлийн байгууллага мөн.

1.2. Газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын журам, тогтоол, Засаг даргын шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.3. Газар нь өөрөө, өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар аж ахуйн тооцооны үндсэн дээр улсын үйлдвэрийн газрын эрхтэйгээр үйл ажиллагаа явуулна.

1.4. Газар нь хотын ерөнхий менежерийн удирдлагын дор ажиллаж, ажлаа тайлагнах бөгөөд газрын даргыг Нийслэлийн Засаг даргын захирамжаар томилно.

1.5. Газрын дарга нь эрх мэдлийнхээ хүрээнд хөрөнгө, мөнгө захиран зарцуулах бөгөөд батлагдсан орон тоо, бүтэц зохион байгуулалтыг үндэслэн ажиллагсадыг томилох, чөлөөлөх асуудлыг тушаалаар шийдвэрлэнэ.

1.6. Газар нь тогтоогдсон журмын дагуу тэмдэг, тушаал, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Газрын гүйцэтгэх үүрэг:

2.1. Нийслэлийн хэмжээнд хийх хөрөнгө оруулалт, Төсвийн батлагдсан хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, захиалагчийн болон техникийн хяналтын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах.

2.2. Шинээр барих, шинэчлэн өргөтгөх, засварлах тохижуулах зам, гүүр, барилга, инженерийн байгууламж, тохижуулах объектын техник, эдийн засгийн

64

үндэслэл, тооцоо, зургын даалгаврыг боловсуулан зураг төслийг захиалган хийлгэх.

2.3. Барилга, хөрөнгө оруулалт, хот тохижилтын талаар шинээр гарч буй норм, норматив, дүрэм, журам, заавар бусад хууль эрхийн актыг мөрдүүлэх сурталчлах, хэрэгжүүлэх ажилд хяналт тавьж ажиллах.

2.4. Нийслэлийн захиалгаар шинээр барих, их засвар хийх, тохижуулах бүх барилга байгууламж, зам засвар, цэцэрлэгжилт, гэрэлтүүлэг, реклам чимэглэл, хөшөө дурсгалын ажилд шаардагдах хөрөнгийн хэмжээг тооцон жилийн болон хэтийн төлөвлөгөөнд тусгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих.

2.5. Төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх барилга угсралт, их засвар, хот тохижилтын ажлыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх байгууллагыг тендер зарлан шалгаруулах, мөн найдвартай гүйцэтгэгч байгууллагуудыг сонгон шууд захиалга өгч байх

2.6 Барилга угсралт, их засвар, тохижилт арчилгааны ажлыг барилгын болон тохижилтын байгууллага аж ахуйн нэгж, хүмүүстэй хэлцэл хийж, гэрээ байгуулан үе шат бүрт нь техникийн хяналтыг зохих журмын дагуу явуулж, гүйцэтгэсэн ажлыг баталгаажуулан санхүүжилт хийх

2.7 Хотын авто зам, талбайн хэвийн байдалд хяналт тавьж эвдрэл гэмтлийн хэмжээг гаргаж засах хөрөнгийн эх үүсвэрийг тогтоож засаж хэвийн байдалд оруулах ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх

2.8 Замын тэмдэг, тэмдэглэгээ, дохиог авто замын барилга засварын ажилтай уялдуулан хийлгэх, шинэчлэх бодлогыг барьж түүний хэвийн ашиглалтыг хангах

2.9 Хотын замын сүлжээг өргөтгөх, түүний нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх асуудлыг хот байгуулалтын бодлого, хотын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан дэс дараатай, бодлого чиглэлтэй шийдвэрлэх.

2.10. Хотыг цэцэрлэгжүүлэх ажлыг хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, парк цэцэрлэг байгуулах, гэр хорооллыг ойжуулах замаар хотыг цэцэрлэгжүүлэх, ногоон байгууламжийн арчилгаа, тордолгоо, цэцгийн мандал байгуулах зэрэг хотыг цэцэрлэгжүүлэхтэй холбогдсон ажлын нэгдсэн бодлогыг явуулах.

2.11. Хотын гудамж талбайн гэрэлтүүлгийг сайжруулах, реклам чимэглэлээр хотыг чимэглэх, шинээр байгуулах, орчин үеийн стандартад тэнцсэн реклам, самбарыг хотод байгуулах, сурталчлах ажлыг хот чимэглэлийн бодлого болгон явуулах.

2.12. Хотын төвлөрсөн хогийн цэгийн байршлыг тогтоох, хогийг дарж устгах, ариутгах тэнд ажиллах машин техникийг шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг байнга хийж, зэрлэг нохой муур агнах, хог устгах ажлыг хянан санхүүжүүлэх.

2.13. Хотод хөшөө дурсгал барих, засварлаж тохижуулах, архитектурын жижиг байгууламжийг олшруулах, өнгө үзэмжийг сайжруулах ажлыг хот тохижилтын ажлын бүрэлдэхүүн хэсэг болгон зохион байгуулах.

2.14. Далан суваг, ариутгах татуургын байгууламжийн ашиглалт, бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьж, дамжин өнгөрүүлэх чадлыг нь нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бодлогыг явуулж, түүнд шаардагдах хөрөнгө, хүчийг төлөвлөн авч явуулах.

2.15. Хөрөнгө оруулалтын болоод төсвийн санхүүжилт барилга угсралт, тохижилт, их засварын ажил, ашиглалтад оруулах хүч чадал, үндсэн фондын гүйцэтгэлийг гаргаж хугацаанд нь холбогдох газарт мэдээлж байх.

2.16. Хотын инженерийн байгууламжийн одоогийн суурьлагдсан хүчин чадал болон түүнийг хот байгуулалтын бодлоготой уялдуулан өргөтгөж шинэчлэх ажилд техникийн хяналт тавьж, хотын амьдралын хэвийн үйл ажиллагааг хангах бодлогыг барьж ажиллах.

2.17. Дээд байгууллагын шийдвэр, тогтоол, тушаал, захирамжийн биелэлтийг цаг тухайд нь гаргаж биелэлтийг хангуулах.

2.18. Газар нь орлогоороо зарлагаа нөхөж ажиллахын хамт хөрөнгө санхүүгийн чадавхиа нэмэгдүүлэх, эдийн засгийн нөөцөө өргөтгөх бодлого боловсруулж бүрэн аж ахуйн тооцоон дээр ажиллах, гүйцэтгэж буй барилга угсралтын их засвар, тохижилтын ажлын санхүүжилтээс үйл ажиллагааныхаа зардлыг нөхөх зарчмаар ажиллах.

2.19. Хот тохижилтын байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэх, машин механизмаар хангах, хүчин чадлыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бодлогыг жил жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авах.

Гурав. Газрын эрх

3.1. Барилга байгууламж, их засвар, тохижилтын ажлыг чанаргүй хийсэн, батлагдсан зураг эсхизийг зөрчсөн тохиолдолд ажлыг буруутай этгээдийн зардлаар дахин хийлгэх.

3.2. Хэрэв буруутай этгээд гаргасан зөрчлөө арилгаагүй тохиолдолд тухайн байгууллагын барилга угсралтын ажлыг уг зөрчлийг арилгатай зогсоох.

3.3. Барилга угсралт, их засвар, тохижилтын ажлыг эхлүүлэхдээ тухайн ажлыг дууссаны дараа нөхөн сэргээх зардлыг нь тусгуулж, түүний үндсэн дээр хуучин байдалд нь оруулах.

3.4. Гүйцэтгэгч байгууллагууд өгсөн хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулбал гарсан хохирол төлбөрийг арилгуулах, банк, санхүү, хуулийн байгууллагаар хянуулж шалгуулах.

3.5. Хяналт шалгалтын ажлыг мэргэжлийн байгууллага, авторын оролцоотой явуулж илэрсэн зөрчил, доголдлыг арилгуулах, шаардлагатай тохиолдолд зохих хууль дүрмийн дагуу холбогдох хүмүүст хариуцлага хүлээлгэх асуудлыг тавьж шийдвэрлүүлэх.


3.6. Стандарт, техник, технологийн горим зөрчсөн материалыг ашиглахыг зогсоох, дүгнэлт гаргуулах.

3.7. Барилга угсралт, тохижилт их засвар, арчилгааны ажлыг дууссаны дараа гүйцэтгэгч байгууллага хариуцах хяналтын хугацааг тогтоож мөрдүүлэх.

3.8. Барилгын болон тохижилтын ажлын норм, норматив ажлын гүйцэтгэл, үнэлгээг хянаж, үйл ажиллагаанд нь тохирсон санхүүжилт хийх эрх нээх, дутуу гүйцэтгэсэн ажлаас санхүүжилтийг хасах.

3.9. Ажлын шаардлагыг харгалзан харьяа байгууллагуудын дарга, захиралыг томилох, чөлөөлөх саналыг боловсруулж Нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх.

3.10. Барилга угсралт, их засвар, тохижилтын ажлыг гүйцэтгэх явцад мэргэжлийн хяналтыг холбогдох байгууллагуудтай хамтран тавьж оршиж буй дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах.



Нийслэлийн Засаг даргын 2000 оны
... дугаар захирамжийн 2 дугаар
хавсралт

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХОТ ТОХИЖИЛТЫН
ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТООНЫ НЭГЖ

№	Албан тушаал	Орон тоо	Тайлбар
1.	Газрын дарга	1	
2.	Ерөнхий дөндөрлогч, орлогч дарга	1	
3.	Ерөнхий инженер	1	
4.	Авто замын улсын байцаагч	3	
5.	Барилгын ажлын хяналтын инженер	3	
6.	Цахилгаан холбооны ажлын хяналтын инженер	1	
7.	Дулаан, цэвэр, бохир ус, сантехникийн ажлын хяналтын инженер	2	
8.	Замын ажлын хяналтын инженер	3	
9.	Далан суваг, архив хариуцсан инженер	1	
10.	Тохижилтын ажил хариуцсан мэргэжилтэн	1	
11.	Гэрэлтүүлэг, реклам, чимэглэлийн ажил хариуцсан мэргэжилтэн	1	
12.	Төвлөрсөн хог хаягдал хариуцсан мэргэжилтэн	1	
13.	Эдийн засаг, жижиг байгууламж, хөшөө дурсгалын асуудал хариуцсан мэргэжилтэн	1	
14.	Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн	1	
15.	Нягтлан бодогч	2	
16.	Даргын туслах, бичиг хэргийн эрхлэгч	1	
17.	Жолооч	1	
	БҮГД	25	